| 620003 | Үйлчлэх ажилтан | 00.00 | | | |

# 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

## 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн газар нь сумынхаа хүн амд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг тасралтгүй зарчмаар стандартын дагуу чанартай тэгш, шударга жигд үзүүлэх эрхэм зорилгынхоо хүрээнд үйл ажиллагааныхаа зорилтыг тодорхойлжээ.

## 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт *ороогүй* байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудит/аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

## 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Эрдэнэцогт сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь Сангийн сайдын 2018 оны тушаалаар баталсан "Төсөвт байгууллагын жишиг нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг үйл ажиллагаандаа ашиглаж, санхүүгийн тайлан бэлтгэхдээ мөрдөж ажиллаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

## 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Эрдэнэцогт сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 685,535.5 мянган төгрөг буюу 8.3 хувиар *өссөн* байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3 |
| Мөнгөн хөрөнгө | 81,659.88 | 60,555.35 | (21,104.53) |
| Авлага | - | 11,847.72 | 11,847.72 |
| Урьдчилгаа | - | - | - |
| Бараа материал | 135,516.13 | 144,741.90 | 9,225.77 |
| Үндсэн хөрөнгө | 415,906.52 | 468,390.54 | 52,484.02 |
| **Нийт хөрөнгө** | **633,082.53** | **685,535.51** | **(52,452.98)** |
| Өр төлбөр | 1,326.58 | 1,326.58 | - |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 631,755.95 | 684,208.93 | 52,452.98 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **633,082.53** | **685,535.51** | **52,452.98** |

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл нь 60,555.4 мянган төгрөг байгаа нь үндсэн дансны зарцуулагдаагүй үлдэгдлийг татан төвлөрүүлээгүйтэй холбоотой байна.

Авлагын дансны үлдэгдэл 11,847.7 мянган төгрөг байгаа нь гүйцэтгэлээр санхүүжиж байгаатай холбоотойгоор эрүүл мэндийн даатгалын сангаас авах авлагыг тусгасантай холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 144,741.9 мянган төгрөг болж 9,225.8 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн худалдан авалтаар 149,592.4 мянган төгрөгийн бараа материалыг худалдан авч, аймгийн Эрүүл мэндийн газраас 14,911.2 мянган төгрөгийн эм боох материал, аж ахуйн материал, сумын үйлдвэрчний эвлэлийн хорооноос 2420.0 мянган төгрөгийн материалыг үнэ төлбөргүй хүлээн авч, бичиг хэргийн материалаас 3,850.1 мянга, аж ахуйн материал данснаас 3,637.6 мянга, барилгын засварын материалаас 2,464.2 мянга, түлш шатах тослох материал данснаас 28,558.7 мянга, сэлбэг хэрэгсэл данснаас 4212.5 мянга, тусгай зориулалтын материалаас 7,800.1 мянга, эм боох материалаас 82,414.8 мянга, хүнсний материалаас 9,744.3 мянга нийт 144,049.7 мянган төгрөгийг зарцуулж, 13648.1 мянган төгрөгийн эргэлтийн хөрөнгийг акталж, данснаас хассан нь голлох нөлөө үзүүлжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 468,390.5 мянган төгрөг болж 52,484.0 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн худалдан авалтаар 49,115.6 мянга, аймгийн Эрүүл мэндийн газраас 47,650.6 мянга, аймгийн ИТХ-ын даргын 2023 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн 107 дугаар захирамжаар 2,855.6 мянган төгрөгийн өртөг бүхий мотоциклийг үнэ төлбөргүй хүлээн авч, аймгийн ИТХ-ын хуралдааны 2023 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн 13/08 дугаар тогтоолоор 36,742.9 мянга, 2023 оны 10 дугаар сарын 11-ны өдрийн 16/49 дугаар тогтоолоор 5,400.0 мянган төгрөгийн balансын үнэ бүхий тавилга эд хогшил, тоног төхөөрөмжийг данснаас хасах шийдвэр гарсны дагуу акталж, бүртгэлээс хассан байна.

Өглөгийн дансны үлдэгдэл 1,326.6 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос үүссэн ажилчидтай холбоотой хувь хүний орлогын албан татварын өглөгийг төлж барагдуулаагүйтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 684,208.9 мянган төгрөг болж 52,452.9 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн 52,452.9 мянган төгрөгийн өөрчлөлтөөс шалтгаалжээ.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 881,083.9 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 881,083.9 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл зардлыг 21,219.7 мянга, хангамж, бараа материалын зардлыг 11,078.8 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн, цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардлыг 53,758.8 мянга, нормативд зардлыг 24,907.0 мянга, эд хогшил, урсгал засварын зардлыг 95,800.0 мянга, томилолт, зочны зардлыг 4,100.0 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийг 20,696.6 мянга, бараа үйлчилгээний бусад зардлыг 88,629.3 мянган төгрөгөөр бууруулж 844,007.1 мянган төгрөгөөр баталсан байна.

Энэ нь төсвийн төслийг бодитой, үндэслэлтэй боловсруулаагүй гэж үзэхээр байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд улсын төсвийн санхүүжилтээр 844,007.1 мянга, орон нутгийн төсвөөс 43,029.5 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас гүйцэтгэлээр эрүүл мэндийн даатгалын сангаас 683,974,0 мянга, орон нутгийн төсвөөс 43,029.5 мянган төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 741,982.0 мянган төгрөгийг зарцуулж, 6,126.0 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 741,982.0 мянган төгрөг буюу нийт батлагдсан төсвийн 83.7 хувийг зарцуулсан байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардлаас 107,250.1 мянга, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 12,166.4 мянга, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 4,626.0 мянга, хангамж, бараа материалын зардал 6,995.9 мянга, нормативд зардал 3,920.4 мянга, эд хогшил урсгал засварын зардал 2,044.6 мянга, томилолтын зардал 624.0 мянга, бараа үйлчилгээний бусад зардал 4,464.9 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 2,916.7 мянган төгрөгийг хэмнэсэн нь голлох нөлөөг үзүүлж байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1 | **71602 Эмнэлгийн тусламж үйлчилгээ** | **887,036,680.95** | **741,981,999.11** | **145,054,681.84** | **83.7%** |
| 1 | 80302 Нэг иргэнд ногдох нормативаар | 572,028,700.00 | 466,491,543.73 | 105,537,156.27 | 81.6% |
| 2 | 81603 үндсэн мэргэжлийн тусламж үйлчилгээ | 190,318,600.00 | 163,266,611.51 | 27,051,988.49 | 85.8% |
| 3 | 83603 Нэмэлт - Дээд шатны төсвөөс хуваарилсан | 81,659,880.95 | 75,320,379.00 | 6,339,501.95 | 92.2% |
| 4 | 80112 Нийтлэг үйлчилгээ | 43,029,500.00 | 36,903,464.87 | 6,126,035.13 | 85.8% |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд тус байгууллага нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3-д заасны дагуу шууд худалдан авалт хийсэн байна.

Тус байгууллага нь тавилга эд хогшил худалдан авах гэрээг Үржин тэнгис ХХК-тай 18,760.0 мянган төгрөгөөр авахаар шууд гэрээ байгуулж ажилласан байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Эрдэнэцогт сумын Эрүүл мэндийн төв нь 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Нарангэрэл гүйцэтгэж, чанарын хяналтыг ахлах аудитор М.Алтантуяа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Эрдэнэцогт сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлгэх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 108 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны жилийн

эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 689,396.9 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 10,340.9 мянга, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 7,238.7 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор 2023 оны байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 4,626.0 мянга буюу 11.1 хувь, бичиг хэргийн зардлыг 264.6 мянга буюу 6.8 хувиар нийт 4,890.6 мянган төгрөгийн хэмнэлт бий болгосон байна.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээлбэл зохих хуулийн 6.4.5 “Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого зарлагын мөнгөн гүйлгээ”-д заасан орлогын 80,452.7 мянган төгрөгийн 6 мэдээлэл, зарлагын 6126.0 мянган төгрөгийн 1 мэдээлэл, 6.4.8 ”Төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн мэдээлэл” -д заасан 4 гэрээг байршуулаагүй байна.

*Шийдвэрлэсэн нь*: Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5, 6.4.8-д заасан мэдээллийг бүрэн байршуулж, зөрчлийг арилгах албан шаардлага өгөв.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Тайлант хугацаанд завсар үеийн аудит хийгдээгүй болно.

#### 4.5.1 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитыг Глобал капитал аудит ХХК хийж гүйцэтгэсэн бөгөөд аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

байхгүй

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 9,963.1 мянган төгрөгийн 2 алдаа[1] илэрснээс аудитын явцад залруулав. Үүнд:

1. Тайлант хугацааны цалингийн зардал нь үр дүнгийн тайлангаас 182.1 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн байгаа нь УСНББОУС-1 Толилуулга ба тодруулга, мөн иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.
2. Аймгийн Эрүүл мэндийн газраас хуваарилсан 9,781.0 мянган төгрөгийн хөрөнгийг санхүүгийн тайланд бүртгээгүй, мөн үндсэн хөрөнгийн бүртгэлд 0 төгрөгийн үнэлгээтэй хөрөнгүүдийг бүртгэсэн байгаа нь УСНББОУС-17 Үндсэн хөрөнгө, мөн иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Аудитаар нийт 126,860.3 мянган төгрөгийн 9 зөрчил[2] илэрснээс 1044.0 мянган төгрөгийн 2 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 122,133.8 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 5 албан шаардлага, зөрчлийг давтан гаргахгүй байх 3,682.5 мянган төгрөгийн 2 заалт бүхий зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 40,281.6 мянган төгрөгийн материаллагаар тооцсон залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 33,042.9 мянган төгрөгөөр их тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

### 5.1 Төлбөрийн акт

5.1.1 Томилолтын зардлыг тулгахад сунгалт хийгээгүй байхад шийдвэрт тэмдэглэсэн хоногоос илүү олгосон 590.0 мянган төгрөгийн 5, ирсэн явсан хугацааг тэмдэглээгүй 354.0 мянган төгрөгийн 1, нийт 944.0 мянган төгрөгийн томилолтыг журам зөрчиж олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Засгийн газрын 2019 оны "Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам"-ын 2.4 “Албан томилолтоор ажилласан хоногийн тоог албан томилолтоор ажиллуулах шийдвэрт тэмдэглэсэн хуанлийн хоногоор тооцож гаргана. Албан томилолтоор явсан, буцаж ирсэн өдрийг нэгтгэн нэг хоногт тооцно”, 2.8 “ Томилолтын хугацааг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хэтрүүлсэн тохиолдолд хэтрүүлсэн хугацааны байр, хоолны зардлыг олгохгүй” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

<u>*Шийдвэрлэсэн нь*</u>: Хяналт хэрэгжүүлээгүй холбогдох буруутай албан тушаалтнуудаар буцаан төлүүлж, төлбөрийн актыг тогтоов.

5.1.2 Байгууллагын дарга нь 2023.04.27-ны өдрийн А/09 дүгээр тушаалаар өөртөө шийдвэр гарган урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах замын зардал болох 100.0 мянган төгрөгийг хүлээн авсан байна.

---

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Энэ нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1[3] дэх заалтыг зөрчсөн байна.

*Шийдвэрлэсэн нь*: Төсвийн захирагчаар 100.0 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

## 5.2 Албан шаардлага

5.2.1 Тус байгууллага нь өмнөх оноос үүссэн 1,326.6 мянган төгрөгийн ХХОАТ-ын өглөгийг барагдуулаагүй, тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.8[4] дахь заалт, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.5[5] дахь заалттай нийцэхгүй байна.

*Шийдвэрлэсэн нь*: Хувь хүний орлогын албан татварын зөрүүг үнэн зөв тооцоолж, тухай бүр нь тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулан өр төлбөрийг барагдуулж, цаашид алдаа зөрчлийг дахин давтан гаргахгүй байх албан шаардлагыг хүргүүлэв.

5.2.2 Байгууллагын даргын тушаалаар томилогдсон тооллогын комисс нийт 14,816.7 мянган төгрөгийн хөрөнгийг тоолоогүй, нягтлан бодогч тооцоо бодсон акт үйлдээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1[6] ,13.6[7], 18.1[8], 20 дугаар зүйлийн 20.1.4[9], 20.2.6[10] дэх заалтуудыг зөрчиж байна.

*Шийдвэрлэсэн нь*: Жилийн эцсийн тооллогыг үнэн зөв тухай бүр тооцоо нийлж үлдэгдлийг баталгаажуулж, зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

5.2.3 Тайлант хугацааны нярвын тайлан нь санхүүгийн тайлангаас орлого 8,863.9 мянга, зарлага 5,116.9 мянган төгрөгөөр дутуу илэрхийлэгдсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1[11] дэх заалттай нийцэхгүй байна.

*Шийдвэрлэсэн нь*: Няравын тайланг үнэн зөв гаргаж, нягтлан бодогч хянаж хүлээн авч зөрчлийг арилгах, цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага өгөв.

5.2.4 Байгууллагын өмч хамгаалах зөвлөл нь 5,431.0 мянган төгрөгийн барилгын урсгал засвар болон тээврийн хэрэгслийн сэлбэг хэрэгслийг сольж засварлахдаа байгууллагын өмч хамгаалах зөвлөлөөр хэлэлцүүлээгүй, дүгнэлт гаргаагүй байна.

---

[3] Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно

[4] төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх.

[5] хуваарьт болон хугацаа хэтэрсэн өр төлбөрийг жилийн төсөвтөө бүрэн тусгаж өр төлбөр барагдуулах төлөвлөгөө, хуваарь батлаж хэрэгжүүлэх;

[6] Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно

[7] Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна

[8] Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ

[9] хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх

[10] Хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах

[11] Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно

Энэ нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2018 оны "Өмч хамгаалах зөвлөлийн үйл ажиллагааны нийтлэг журам"-ын 3.13[12] дахь заалттай нийцэхгүй байна.

*Шийдвэрлэсэн нь*: Байгууллагын авто тээврийн хэрэгсэлд хийсэн урсгал засвартай холбоотой тооцооллыг өмч хамгаалах зөвлөлөөр хэлэлцүүлэн дүгнэлт гаргуулж, зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

5.2.5 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 80,452.7 мянган төгрөгийн 6 гүйлгээ, 6,126.0 мянган төгрөгийн зарлагын 1 гүйлгээг мэдээлээгүй, мөн цахилгаан, дулаан, шатахуун, хүнс нийлүүлэх гэрээг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5[13], 6.4.8[14] дахь заалтуудыг зөрчиж байна.

*Шийдвэрлэсэн нь*: Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5-д заасан 51,184.7 мянган төгрөгийн 4 мэдээлэл, 6.4.8-д заасан 20,440.6 мянган төгрөгийн 6 мэдээллийг бүрэн байршуулж, зөрчлийг арилгах албан шаардлага өгөв.

**5.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Зардлын данстай холбоотой асуудал

*Илрүүлэлт:* Эм, эмнэлгийн хэрэгслийн зардлаас хүнсний зардалд 228.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан "Эдийн засгийн ангилал ашиглах заавар"-ыг зөрчсөн байна.

*Өгсөн зөвлөмж*: Цаашид эдийн засгийн ангилал хооронд гүйлгэн зарцуулдаг байдлыг таслан зогсоож зөрчлийг дахин давтан гаргахгүй байх.

2. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой асуудал

*Илрүүлэлт:* Тайлант хугацааны төсвийн гүйцэтгэлийн тайлан төсвийн хэлбэлзлээс 3,454.5 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2[15], 41.2.3[16] дахь заалтыг тус тус зөрчсөн байна.

*Өгсөн зөвлөмж*: Цаашид төсвийг зарцуулахдаа батлагдсан төсвийн хүрээнд зарцуулж, төсвийн гүйцэтгэлийн тайланг үнэн зөв илэрхийлж байх зөвлөмжийг хүргүүлэв.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 05 дугаар сарын 15 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

[12] Өмч хамгаалах зөвлөл нь хуулийн этгээдийн тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн ашиглалт, сэлбэг эд ангийг солих, барилга байгууламжийн их засвар хийх тохиолдолд батлагдсан норм норматив, стандартыг мөрдүүлэх, барилгын болон техникийн хувийн хэрэгт нь баяжилт хийлгэх зэргээр хяналт тавьж ажиллана

[13] Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр

[14] Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр

[15] батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах;

[16] төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл** /мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үнэнээс | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Санхүүгийн тайланд буруу бүртгэсэн | 0 | 0 | | | 0 | 0 | 0 | 0 | | |
| Санхүүгийн тайланд бүртгээгүй | 2 | 9,963.1 | 2 | 9,963.1 | | | 2 | 9,963.1 | | |
| Дүн | **2** | **9,963.1** | **2** | **9,963.1** | | | **2** | **9,963.1** | | |

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Томилолтын зардлыг тулгахад сунгалт хийгээгүй байхад шийдвэрт тэмдэглэсэн хоногоос илүү олгосон 590.0 мянган төгрөгийн 5, ирсэн явсан хугацааг тэмдэглээгүй 354.0 мянган төгрөгийн 1, нийт 944.0 мянган төгрөгийн томилолтыг журам зөрчиж олгосон байна. | 1 | 944.0 | 1 | 944.0 | | | | |
| Байгууллагын дарга нь 2023.04.27-ны өдрийн А/09 дүгээр тушаалаар өөртөө шийдвэр гарган урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах замын зардал болох 100.0 мянган төгрөгийг хүлээн авсан байна. | 1 | 100.0 | 1 | 100.0 | | | | |
| Тус байгууллага нь өмнөх оноос үүссэн 1,326.6 мянган төгрөгийн ХХОАТ-ын өглөгийг барагдуулаагүй, тооцоо нийлж баталгаажуулаагүй байна. | 1 | 1,326.6 | | | 1 | 1,326.6 | | |
| Байгууллагын даргын тушаалаар томилогдсон тооллогын комисс нийт 14,816.7 мянган төгрөгийн хөрөнгийг тоолоогүй, нягтлан бодогч тооцоо бодсон акт үйлдээгүй байна. | 1 | 14,816.7 | | | 1 | 14,816.7 | | |
| Тайлант хугацааны нярвын тайлан нь санхүүгийн тайлангаас орлого 8,863.9 мянга, зарлага 5,116.9 мянган төгрөгөөр дутуу илэрхийлэгдсэн байна. | 1 | 13,980.8 | | | 1 | 13,980.8 | | |
| Байгууллагын өмч хамгаалах зөвлөл нь 5,431.0 мянган төгрөгийн барилгын урсгал засвар болон | 1 | 5,431.0 | | | 1 | 5,431.0 | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| тээврийн хэрэгслийн сэлбэг хэрэгслийг сольж засварлахдаа байгууллагын өмч хамгаалах зөвлөлөөр хэлэлцүүлээгүй, дүгнэлт гаргаагүй байна. | | | | | | | | |
| Эм, эмнэлгийн хэрэгслийн зардлаас хүнсний зардалд 228.0 мянган төгрөгийг зарцуулсан байна. | 1 | 228.0 | | | | | 1 | 228.0 |
| Тайлант хугацааны төсвийн гүйцэтгэлийн тайлан төсвийн хэлбэлзлээс 3454.5 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн | 1 | 3,454.5 | | | | | 1 | 3,454.5 |
| **Нийт дүн** | **8** | **40,281.6** | **2** | **1,044.0** | **4** | **35,555.1** | **1** | **3,682.5** |

## Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуультай холбоотой зөрчил | | | | | | | | |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 80,452.7 мянган төгрөгийн 6 гүйлгээ, 6,126.0 мянган төгрөгийн зарлагын 1 гүйлгээг мэдээлээгүй, мөн цахилгаан, дулаан, шатахуун, хүнс нийлүүлэх гэрээг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулаагүй байна. | 1 | 86,578.7 | | | 1 | 86,578.7 | | |
| Дүн | **1** | **86,578.7** | | | **1** | **86,578.7** | | |

------------oOo-------------